

# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЫЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05-р сарын 25-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайланг батлах, ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн  
ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг баталсугай.
2. Компани 2015 онд алдагдалтай ажилласан байх ба банкны өмнө хүлээсэн гэрээний үүргийн дагуу ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.



# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЫЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05-р сарын 25-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн  
ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн Гүйцэтгэх захирадл дор дурдсан арга хэмжээг авч ажиллан  
үр дүнгийн талаар ТҮЗ-д тайлагнаж ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 1/ “Хөнгөн бетон” ХК-ийн үндсэн хөрөнгийн зах зээлийн үнэлгээг үнэлгээний байгууллагаар гаргуулж, уг хөрөнгийг зарж борлуулах хэлбэрээр банкин дээр болон хувь хүн, байгууллагад үүсээд буй хугацаа хэтэрсэн зээлийн өрийг барагдуулах,
- 2/ Барилгын салбарын уналттай холбоотой компанийн борлуулалт буурсан тул компанийн газар болон үл хөдлөх хөрөнгийг зарж борлуулах, түрээслүүлэх арга хэмжээ авч ажиллах,
- 3/ МУ-ын Хөгжлийн банк, Арилжааны бүх банкууд, ББСБ болон хувь хүн, ЖДУ-ийн сан, ЖАЙКА, ЕСБанк, АХБанк, бусад гадаадын банкуудаас томоохон зээл авч, одоо байгаа хүндрэлээс гарч үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор зээлийн гэрээнд гарын үсэг зурах,
- 4/ Дээрхи зээлүүдтэй холбоотой “Хөнгөн бетон” ХК-ийн нэр дээрхи газар болон үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгүүдийг барьцаалах, барьцааны гэрээнд гарын үсэг зурах, их хэмжээний хэлцэл хийх,
- 5/ “Бэст Терминал” ХХК-тай удааны хугацааны түрээсийн гэрээ буюу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

ХУРЛЫН ДАРГА  Б.НАРАНЗУЛ

# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05-р сарын 25-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх  
зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

- ХАС банкаар дамжуулан ЕСББ-ны санхүүжилтээр авсан 1540000135 тоот зээлийн гэрээний үлдэгдэл болох 1,260,000 ам.долларын зээлийг тухайн өдрийн Арилжааны банкны ханшаар тооцон төгрөгийн зээлд хөрвүүлэн шилжүүлэхийг зөвшөөрөх.
- ХАС банкаас ЕСББ-ны санхүүжилтээр авсан 1540000135 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 1,260,000\$, ЗГ-ын үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн дагуу Хас банкаар дамжуулан авсан 1540000172 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 333,323,870 төгрөгийн 2 зээлийн нийт үлдэгдлийг тухайн өдрийн зээлийн хорооны шийдвэрийн ханшаар төгрөгийн зээл рүү хөрвүүлж, хуучин барьцаалж байсан хөрөнгүүдийг эргүүлэн барьцаалахыг зөвшөөрөх.
- Дээрхи зээлтэй холбогдуулан Гүйцэтгэх захирал Л.Даваанямд хөрөнгүүдийг ХАС банкны зээлийн барьцаанд тавьж, захиран зарцуулах, үүргийн гүйцэтгэл хангуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг олгох.

ХУРЛЫН ДАРГА *З. Наранзул* Б.НАРАНЗУЛ



# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05-р сарын 25-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 75, 78 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн ТҮЗ-д дор дурдсан гишүүдийг улируулан сонгосугай. Үүнд:

1/ ТҮЗ-ийн ердийн гишүүд:  
Баярхүү овогтой Наранзул  
Баярхүү овогтой Наранцацралт  
Тошил овогтой Баярхүү

2/ ТҮЗ-ийн хараат бус гишүүд:  
Алтангэрэл овогтой Мөнхзул  
Шаравсамбуу овогтой Энхтөр

2. “Хөнгөн бетон” ХК-ийн ТҮЗ-д дор дурдсан гишүүдийг шинээр сонгосугай. Үүнд:

1/ ТҮЗ-ийн ердийн гишүүд:  
Болд овогтой Батбаяр  
Бат-очир овогтой Эрдэнэбаяр  
Баасанжав овогтой Алтанцэцэг

2/ ТҮЗ-ийн хараат бус гишүүд:  
Нямдорж овогтой Мөнхцацрал

ХУРЛЫН ДАРГА Н.Наранзул  
Б.НАРАНЗУЛ  


# “ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05-р сарын 25-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүдийн цалин,  
зардлын хэмжээ тогтоох тухай

“Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйл 62.1.13 дахь заалтыг үндэслэн  
ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн ТУЗ-ийн даргын цалинг хэвээр буюу 3,700,000 (Гурван  
сая долоон зуун мянга) төгрөгөөр батласугай.
2. ТУЗ-ийн бусад гишүүдийг цалингүй ажиллуулсугай.
3. Хуралд ирсэн гишүүдэд унааны зардлыг 20,000 төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НАРАНЗУЛ